

**Бакалаврын сургалтын хөтөлбөрийг харьцуулан үнэлэх аргазүйн
загвар боловсруулан судалсан зарим үр дүнгээс
(МУБИС болон ӨМБИС-ийн хөтөлбөрийн жишээн дээр)**

Ж. Жилээ

Өвөр Монголын Багийн Их Сургууль

Хураангуй.

Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулах, үнэлэх, хэрэгжүүлэх, бодлогын хувьд залгамж чанартай болгох шаардлага байна. Энэ утгаараа боловсролын философийн орчин үеийн урсгал, үнэт зүйлсийг сургалтын хөтөлбөрийн зорилго, бүтэц, агуулгыг тодорхойлоход харгалзсан байх, эсвэл боловсруулсан хөтөлбөрийг философи урсгал, чиглэлийг хэрхэн баримталж буйг үнэлэх ажил чухал байна.

Бид судалгааны ажлын хүрээнд ӨМБИС болон МУБИС-ийн график дизайны бакалаврын сургалтын хөтөлбөрийг баримт бичгийн түвшинд харьцуулан судалж, хоёр хөтөлбөрийн онцлог шинж, боломж болон давуу талуудыг илрүүлж, сул тал болон эрсдэлт байдлыг нөхөх стратеги тодорхойлох арга зүйн нэгэн хувилбар боловсруулан турших зорилгыг тавьсан. Энэ хүрээндээ хөтөлбөрийн онол, аргазүй, чиг хандлагыг судлах, хөтөлбөрийг үнэлэх загвар, аргазүйн хувилбар боловсруулах, хоёр хөтөлбөрийн үндсэн үзэл баримтлал болон боловсруулалтын харьцуулсан судалгаа, үнэлгээ дүгнэлт хийх, график дизайны хоёр хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, үр дүнгийн хамаарлын тодорхойлсон байдлыг үнэлэх, харьцуулалт хийх, агуулга, аргазүйн харьцуулсан судалгаа хийх, үнэлгээний тогтолцоо болон хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, чанарыг баталгаажуулах тогтолцоо, хөтөлбөрийн бичиг баримтад хэрхэн туссан тухай харьцуулах, сул тал болон эрсдэлийг нөхөх, боломж болон давуу талыг улам сайжруулах стратеги боловсруулах, санал зөвлөмж гаргах гэх мэтээр олон зорилтыг хэрэгжүүлсэн судалгааны ажлуудыг хийлээ.

Бид энэ ажлаар хамтын ажиллагаатай 2 сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулахад баримталж буй бодлого, тогтоол, тушаал шийдвэр, хөтөлбөрийн үзэл баримтлал, хөтөлбөрийн зорилго зорилт, зарчим сургуулийн болон тэнхимийн эрх хэмжээ, түүнийг хязгаарлаж буй эсэх, улмаар дэлхий нийтийн өнөөгийн хандлагатай хэрхэн уялдаж буй байдлыг судлан тодорхойлов.

Түлхүүр үг

Сургалтын хөтөлбөр, Хөтөлбөрийн үнэлгээ, Хөтөлбөрийн харьцуулалт, Хөтөлбөр судлал,

Удиртгал

Сургалтын хөтөлбөрийн орчин үеийн хандлагатай судлах зүйл хэрхэн нийцж буйг тодорхойлох, хөтөлбөрийг боловсруулалтын түвшинд үнэлэх загвар боловсруулан харьцуулсан судалгааны аргазүйг ӨМБИС болон МУБИС-ийн график дизайны хөтөлбөрт хэрэглэж буй анхны тохирол учир онол аргазүйн болон практикын хувьд шинэлэг бөгөөд ач холбогдолтой бөгөөд харьцуулан судлаж буй хоёр хөтөлбөрийн давуу ба сул тал, ижил болон ялгаатай тал, мөн онцлог шинжийг нь илрүүлэх, тэдгээрийн харилцан нэгнээ нөхөх боломжтой эсэхийг тодорхойлох үндсэн суурь болох хөтөлбөрт тодорхойлсон суралцахуйн үр дүнгээ хэрхэн хэрэгжүүлж буйг суралцагчдын бүтээлийг хөндлөнгөөс харьцуулан үнэлэх нэгэн аргазүйг боловсруулан турших, хэрэглээ болгох нь чухал хэрэгцээтэй

хэмээн үзсэн болно.

Харьцуулан судалж буй хоёр хөтөлбөрт давуу болон сул тал буй бөгөөд нэг нь нөгөөгөө сайжруулах онцлог шинжийг аль аль нь агуулж байгаа учир түүнд тулгуурлан хөтөлбөрийн боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд анхаарах зүйлсийг тодорхойлох боломжтой байна хэмээн үзэв.

Үндсэн хэсэг.

Сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, бүтэц, үр дүнгийн тухай боловсролын философийн хэд хэдэн урсгал чиглэлийг өнөөгийн улс орнууд баримталж байна. Эдгээр урсгалын үндэслэлээс зонхилон баримтлал болж буй нь переннеализм, эссенциализм,

прогрессивизм, экзистенциализм, нийгмийн реконструктивизм, прагматизм, фрейдизм, бихевиоризм зэрэг билээ.

Энэ философи урсгал, үнэт зүйлс бидний судлан буй хөтөлбөрүүдэд хэрхэн туссан тухай үнэлгээг хийх, чиг хандлага нь ямар байгааг тодорхойлохыг илүүтэй үзэж байгаа болно. Мөн танин мэдэхүйн онол, зарчим хэрхэн тусгаж, бас баримталж буйг тодруулахыг хүссэн юм.

Танин мэдэхүйн онол бүр нь хүний хөгжлийг аль нэг талаас нь авч үздэг онцлогтой байдаг тул нэг онол баримталж хөтөлбөр боловсруулах нь өөрөө өрөөсгөл зүйл болно. Гэхдээ энэ онолд хэт дулдуйдахгүй байх. “Хөтөлбөр боловсруулахдаа онолд хэт дулдуйддаг. Бодит практик, түүний үйл явц, үйл ажиллагааны үр өгөөжийг гүйцэд ойлгож, судалж байж хөтөлбөр боловсруулах ёстой. Хөтөлбөр боловсруулах, сайжруулах нь багш, сургуулийн түвшний үзэгдэл юм (Schwabb, 1972)” гэж дүгнэж байсныг ч бид тооцох ёстой.

Харин боловсруулсан хөтөлбөрт боловсролын сэтгэл судлалын болон танин мэдэхүйн онолуудыг хэрхэн харгалзсан тухай судлан үзэх нь зүйтэй хэмээн үзэж байна. Тухайлбал:

- Сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээ, судлагдахууныг тодорхойлохдоо мэдлэгийг бүтээлчээр эзэмших замаар хувь хүний дасан зохицох үйл явцыг сайжруулахад чиглэсэн оюун ухааны хөгжлийн тухай онол (Ж.Пиаже)-ийн суралцагчийн оюун санааны үе шат, боломжид тулгуулах, мөн суралцагчийн хийсвэр сэтгэлгээний онцлогт тулгуулаж, үйлдлийн тогтолцоог эзэмшүүлэх, мэдлэг бүтээх, мэдлэгийн бүтцийг интеграцилах аргуудыг хэрэглэсэн байдал
- Мөн сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээ, судлагдахууныг тодорхойлохдоо суралцах үйл болон оюутны үйлийн баримжаалалыг зөв тодорхойлоход чиглэгдсэн суралцагчийн оюуны үйлийн “ойрын бүс” өнөөдөр хараахан хийж чадахгүй байгаа боловч маргааш хийх чадах зүйлд тулгуурлаж, оюуны үйлийг шатлан төлөвшүүлэх аргаар хэрэгждэг Сургалт ба хөгжлийн харилцааны тухай онол (Л.С.Выготскийн) хэрхэн тооцсон г.м
- Мөн сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээ, судлагдахууныг тодорхойлохдоо оюун ухааныхаа онцлог, чадамжийн хэр хэмжээгээр хөгжих боломжийг суралцагч бүрт олгоход чиглэсэн суралцагч бүрийн хувийн онцлогийг харгалзсан Оюун

ухааны цогцолбор онол (Х.Гарднерийн)-ыг хэрхэн тусгасан бөгөөд цаашилбал, Э.Эриксоны Эго онол, Б.Д.Элькүнины Үйл ажиллагааны онол, Маслоугийн Хүмүүнлэгийн онол, К.Юнгийн Аналитик онол, бихевиоризм буюу дасан зохицохуйн онол зэргийг бидний судалж буй хөтөлбөрт хэрхэн туссан тухай шинжилгээ хийж, онцлог, шинжийг тодорхойлох ажлыг хийж байна.

Эндээс үзэхэд бидний судлан буй хоёр хөтөлбөр тодорхой нэгэн онолд тулгуурлаагүй болох нь харагдаж байгаа бөгөөд аль аль нь суралцахуйн хувь хүний хөгжил төлөвшил, үнэт зүйлд суурилсан суралцахуйн үр дүн, суралцагчийн эзэмшсэн байх мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж, түүндээ суурилан сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээ, судлагдахуунаа тодорхойлох бүтэцтэй байна.

Тэр нь “Тодорхой нэгэн үзэгдэл, үйл явцыг онолын үүднээс тайлбарладаг авч хөтөлбөрийн дизайн нь өөрөө онол биш юм. Түүнийг боловсруулах үйл явц нь гол зарчмууд дээр суурилагаас биш тодорхой нэгэн онолд тулгуурладаггүй. Хөтөлбөр боловсруулах нь сурах үйл ажиллагааг үр өгөөжтэй зохион байгуулахын тулд түүний бүрдүүлбэр хэсэг, хэрэгжүүлэх үйл явц, арга техникийг сонгон төлөвлөж, нэгдмэл болгон зориудаар боловсруулах үйл явц юм” (Pratt, 1994) хадлагатай нийцэж байна.


Энэ хоёр хөтөлбөрийн шинэчлэл хийгдэж тухайн үед “Одоог хүртэл мөрдөж ирсэн хандлагыг өөрчлөх хэрэгтэй. Тухайлбал, нэг үнэн, нэг зөв зам, арга, хандлага, нэг онол, нэг мэргэжил зэрэг үргэлж позитивист байна. Энэхүү хандлага нь олон янзын хэрэгцээ, сонирхол, хувь онцлогтой хүн амын хэрэгцээг хангаж чадахгүй, харин бүгдийг нэг янзаар, хүчээр хөгжүүлж, боловсруулахад чиглэж байна” (Zuga, 1993) гэж үзэж байсанд залруулга хийх шаардлагатай хэмээх чиг хандлага тусгалаа болсон байна.

Сургалтын хөтөлбөрийн харьцуулан судлахад хөтөлбөрийн үнэлгээний загвар, зарчим, хэрэгцээ шаардлага, аргазүйн асуудлыг судлан үзэх нь зүйтэй хэмээсэн. Тайлерын загвар, CIPP загвар, Стайк загвар, Рожейрсын загвар, Скривен загвар, крикпатрикын загваруудад хөтөлбөрийн үзэл баримтлал, зарчим, бүтэц, дизайн, агуулга, аргазүй, үнэлгээ, хэрэгжилт, үр дүнгийг үнэлэх гэсэн нийтлэг зүйлүүдийг үнэлэх тухай туссан байдаг.

Бидний ажилд Context-Input-Process-Product буюу CIPP загварт суурилсан үнэлгээний аргачлалыг гол болгож авсан. Энэ нь хөтөлбөрөөр тодорхойлсон үнэт зүйлийн гол

үзэл санааг философийн орчин үеийн хандлагын үүднээс үнэлэх, үнэт зүйл, баримтлалтайгаа хөтөлбөрийн зорилго, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн хэр хэмжээтэй нийцтэй байгаа байдал, мөн зорилго агуулгын, төлөвлөлт орцын, хэрэгжилт үйл ажиллагааны, үр дүн бүтээгдэхүүний тохироцыг үнэлэх хөтөлбөрийн боловсруулалтын түвшний тогтолцооны үнэлгээний аргазүйг бид боловсруулж судалгаандаа хэрэгжүүлэхээр тогтсон болно.

Зураг 1. Хөтөлбөрийн тогтолцооны үнэлгээний аргазүйн загвар



Хөтөлбөр боловсруулах 5 зарчим баримталсан эсэх үнэлэх нь зүйтэй байна. Тухайлбал,

1. Үзэл баримтлалын: сурах үйл, үйл ажиллагааны
2. Сурах үйлийн талаарх итгэл үнэмшил, хандлагын: сурах үйлийн талаар өөрийн итгэл үнэмшил, хандлагаа эргэцүүлэх боломж
3. Эпистомологийн үндэслэлийн: мэдэх, хийх 2 үйлийн эпистомологи
4. Хөтөлбөрийн төлөвлөлт, боловсруулалтын: хөтөлбөр боловсруулах чадвартай баг
5. Улс төрийн нөлөө, нөхцөл байдлыг ойлгох, тооцох зэрэг болно.

(Feimen-Nemser, 1990; R. Hansen, 1995)


Мөн бид судлагдаж буй 2 хөтөлбөрийг үнэлэх концепцийн хүрээг дараах байдлаар тогтоосон болно. Үүнд

1. Бихейворизм, когнитивизм гм тодорхой онолын үүднээс боловсруулсан уу? (linear model)
2. Үзэгдлийн хандлага /Phenomenological approach/: хүн хэрхэн хөгждөг талаарх багшийн мэдлэг туршлагаас эхтэй бөгөөд суралцагчдын хэрэгцээнд тулгуурлана. Иймээс хөтөлбөр боловсруулахдаа хүн хэрхэн сурдагыг авч үзсэний дараагаар

тэдгээрийн сурах хэв маяг, онцлогт нийцүүлэн арга зүйгээ сонгож эцэст нь агуулгаа тодорхойлсон уу? (blended model)

3. Ямар хөтөлбөрийн хэлбэрт хамаарах вэ? баримт мэдээллийг тогтоолгох (academic curriculum) академик хөтөлбөр үү, эсвэл хийж чаддаг, хэрэглэх чадвар суулгах (utilitarian curriculum) хэрэглээний хөтөлбөр үү?
4. Тодорхой туршлага ажиглалт, эргэцүүлэл - ерөнхийлөл, хийсвэрлэн сэтгэх - шинэ нөхцөлд хэрэглэх арга зарчимд суурилсан эсэх ("Хүний оюуны хөгжил, ялангуяа асуудал шийдвэрлэх чадвар нь тухайн хүн, нийгмийн орчин хоёрын харилцан үйлчлэл дор явагдана" J. Dewey)
5. Сурах үйлийн талаарх итгэл үнэмшил, хандлага ямар байна вэ? Боловсрол нь хичээл төвтэй бус харин асуудал төвтэй байна. Иймээс салангид хичээлүүдийн интеграцчилал дээр санаа, концепцийн учир холбогдлыг тайлах нь чухал чадвар болох бөгөөд сургалтын материал, сурах үйл ажиллагааг сонгохдоо хөтөлбөрийн уян хатан шинжийг хангах нь зүйтэй гэж үзэж байна уу?
6. Аливаа хөтөлбөрийг боловсруулах үйл явц нь янз бүрийн нөхцөл, түвшинд хэлэлцэгдэж дүр төрхөө олж байдаг олон талт үйл явц юм. Өөрөөр хэлбэл энэ нь нийгэм, улс төрийн нөлөөнд байдаг зүйл (Goodson, 1991). Улс төрийн нөлөө хэр байна вэ?
7. Хичээл хоорондын уялдаа харах макро үзэл, сурах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөлтийг харах микро үзэл болон суралцагчдын хэрэгцээ, онцлог, нутаг орны онцлог, нийгмийн шаардлага, сурах онолууд, суралцагчдын үнэлгээ, хөтөлбөрийн үнэлгээ

Хөтөлбөрийн үйл ажиллагааг үнэлэх загвар
Зураг 2. Сургалтын хөтөлбөрийн бүтэц, дизайны харьцуулалт



ӨМБИС нь хөтөлбөр нь үндсэн хөтөлбөрийг боловсруулах зарчим, Сургалтын цагийн төлөвлөлт, Сургалтын дүрэм журмын зохицуулалт ба кредит цагийн хэмжээ, кредитийн хуваарилалт, сургалтын тогтолцоо ба боловсролын бүтэц, шаардлага, боловсролын 2-р цол хамгаалах мэргэжилтнийг бэлтгэх хөтөлбөрийн нөхцөл гэсэн үндсэн 6 хэсэгтэй. Энэ нь нийтлэг нэг хөтөлбөр мөрдөх онцлогтой. Урлаг дизайн мэргэжлийн боловсролын түүх, орчин үеийн байдал ба хөгжлийн чиг хандлага, чадвартныг хүмүүжүүлэх зорилго, чадвартныг хүмүүжүүлэх тодорхойлолт, сургалтын төлөвлөгөө гэсэн тухайн мэргэжилд хамаарах дагалдах 4 хэсэгтэй байдаг.

ӨМБИС-ийн хөтөлбөр нь улс даяараа мөрдөх нам төрийн бодлогод суурилсан зарчим, шаардлага, чадвартныг хүмүүжүүлэх, заан сургах суурилсан ерөнхий хэсэгтэй байгаагаараа онцлогтой байна. Мөн тухайн мэргэжлээр заан сургах боловсролын түүх, орчин үеийн болон хөгжлийн хандлага, чадвартныг хүмүүжүүлэх зорилго, сургалтын төлөвлөгөө зэрэг нь нийтлэг шинжтэй байна. Гэвч суралцагч талаас нь томъёолоогүй, тухайлбал оюутан юу хийх, үр дүнд хэрхэн хүрэх, хүрсэн эсэхийг хэрхэн хэмжих тухай тодорхой зааж өгсөн зүйл байхгүй байгаа нь харьцуулж буй хөтөлбөрөөс болон сүүлийн үеийн хандлагаас ялгаатай байна.

МУБИС-ийн хөтөлбөр нь ерөнхий танилцуулга, Хөтөлбөрийн зорилго, зорилтууд, Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, Сургалтын төлөвлөгөө, Сургалтын аргазүй, Сургалтын орчин, Элсэгчдэд тавих шаардлага, Хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүн, Чанарын баталгаажуулалт, Харилцаа хамтын ажиллагаа гэсэн 10 үндсэн хэсэгтэй мэргэжил бүхэн тухайн 10 хэсгээр тусгайлан сургалтын хөтөлбөр боловсруулдаг. МУБИС-ийн хөтөлбөрийн бүтэц дизайн нь барууны шинжтэй, олон улсын чиг хандлага, хөтөлбөр судлалын онол, зарчимд нийцэхүйц бүтэц, дизайнтай байна. Энэ нь мөн ОУ-ын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагатай нийцэж буй байдлаар тодорхойлогдох боломжтой. Үнэт зүйлд суурилсан суралцахуйн үр дүнгээ хэрхэн хэрэгжүүлэх вэ, суралцагч үр дүнд хүрэхийн тулд юу хийх вэ? Суралцагчийн суралцах үйл ажиллагаанд шаардагдах сургалтын орчин, багшлах бүрэлдэхүүний нөөц зэрэг нь ямар байх вэ? Суралцагч үр дүнд хүрсэн болохыг хэрхэн хэмжих вэ гэх зэргээр суралцахуйн үр дүнтэйгээ бүх үйл ажиллагааг холбосон бүтэцтэй байгаа нь онцлогтой байна.

График дизайн мэргэжлээр олгох ёстой чадваруудын судалгаа хийж үзэхэд дараах чадварууд илүүтэй чухал байна. Мэргэжлийн график дизайнер 20 хүнээс график дизайны мэргэжлээр суралцахад ямар чадварууд олгох хэрэгтэй вэ гэдэг асуултын дор чадваруудыг жагсаалгаж мөн өөрийн бичсэн чадварын хамгийн чухал нь аль нь вэ гэж эрэмбэ хийлгэсэн.

Энд хосын харьцуулалтын арга ашигласан болно. Ингэхэд дараах үр дүн 10 аас дээш удаа давтагдсан дараах 12 чадварыг нэрлэсэн үр дүн гарч байна. Мөн дараах байдлаар эрэмблэгдэж байна. Үүнд:

1. Чөлөөтэй сэтгэх
2. Шинийг санаачлах
3. Судлан шинжлэх, бүтээлийн судалгаа
4. Зурах, зохиомжлох
5. Загварчлах, загвар бүтээх
6. Турших, хэрэглэх
7. Санаагаа илэрхийлэх
8. Нийгмийн харилцаа орох багаар ажиллах
9. Дасан зохицох чадвар, орчин орох
10. Мэргэжлийн ёс зүйг баримтлах
11. Мэдээллийн технологийн хэрэглэх
12. Тасралтгүй суралцах

Эдгээр чадварыг хөтөлбөрт хэрхэн эзэмшүүлж буйг шинжлэх шаардлага байгаа гэж үзлээ. Үүний тулд суралцахуйн үр дүн болгож тодорхойлсон байдлыг судлах үзэхийг зорьж байна. График дизайны ажил олгогч нараас шинээр төгсөгчийн чадварын түвшний талаарх асуулгын дүнгээс дараах үр дүн гарч байгаа нь сонирхол татаж байлаа. Монгол улс болон ӨМӨЗО-ны ажил олгогч тус бүр 20 хүнээс дараах асуулгаар судалгаа авч үр дүнг гаргав. Энэ чадваруудыг хөтөлбөрт, суралцахуйн үр дүнд хэрхэн, яаж хэрэгжүүлэхээр тусгасан байдалд шинжилгээ хийх, мөн энэхүү чадваруудыг олгох ямар хичээлүүд буй, ялгаа байгаа эсэх зэргийг тодорхойлохыг чухалчилж байна.

Зураг 3. Чадварын эзэмшиж буй байдал



МУБИС-ийн график дизайн хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийн чиглэл

Чиглэл	Хичээлүүд	кр
Зохиомж	Өнгө зохиомж, Эзлэхүүнт зохиомж	3
Урлагийн түүх	Монголын дүрслэх урлагийн түүх, Дэлхийн дүрслэх урлагийн түүх I, Дизайн түүх	3
Зураг	Галбирын анатоми, Хар зураг I- IV, Уран зураг I- IV, Комик дүрслэл, Дизайн зураггүй 1, Зураг зүй	22
Дизайн	График дизайн I- IV, Үсгийн урлаг I, Интерьер дизайны үндэс, Дүрийн дизайн (Character Design), Орон зайн дизайн, Хэвлэлийн дизайн I, Үйлдвэрлэлийн дизайны үндэс, Реклам сурталчилгааны үндэс, Сав баглаа боодлын дизайн I, II	16
Компьютер график	Дижитал урлаг I, Веб дизайн, Компьютер график I-III, 3 хэмжээст график 1-2, Видео урлаг I- II, Интерактив дизайны үндэс, Фотодизайн, Зураг төсөл загварчлал (CAD)	24
Дадлага	Музейн /танилцах/ дадлага, Хээрийн дадлага, Хэвлэлийн технологийн дадлага, Студийн дадлага	5
	Нийт	72

ӨМБИС-ийн график дизайн хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийн чиглэл

Дизайны түүх онол	Орчин үеийн дизайны дэлхийн түүх, Цөөхөн тоот үндэстний урлагийн судлал, Дизайны тойм, Дизайны өнгө, Дизайны сэтгэлзүй	18
Зохиомж	2 хэмжээст зохиомж, 3 хэмжээст зохиомж	9
Зурах, урлах	Дизайны хар зураг I, Дизайны хар зураг II, Ардын уран зураг, Чимэглэлийн зураг, чимэглэлийн шуумал, Үндэстний хээ угалз ба засал чимэглэл, Зар сурталчлалгааны текст, Фото зураг, График бүтээх	26
График дизайн	Үсгийн дизайн, Логоны дизайн, Хээ угалзны дизайн, Зар сурталчилгааны дизайн, сав баглааны дизайн, Үзүүлэнгийн дизайн, Дотоод интерьер дизайн, Сэдэвчилсэн дизайн, Сэдэвчилсэн дизайн II, Номын хавтасны дизайн болон Номын хавтаслах дизайн ба зургийн загвар	31
Компьютерийн график	Компьютер дизайн 1-4, Вэб дизайн	13
Үйлдвэрлэл, хэрэглээ, бизнес	Зар сурталчилгааны төсөл болон цуврал бүтээгдэхүүний үйлдвэрлэл, Хэвлэлийн технологи, Зах зээлийн маркетинг, Визуал дүрслэл ба Визуал шоу, Телевизийн зар сурталчилгаа	17
Соёлын дадлага	Хүмүүнлэгийн практик I-II, Урлагийн судалгаа, Мэргэжлийн дадлага, Дизайн болон судалгаа	10
	Нийт, Заавал суралцах 53 кр, Хязартай сангох 39, дурын сонгох 22	

Дүгнэлт

ӨМБИС болон МУБИС-ийн график дизайны бакалаврын сургалтын хөтөлбөрийг баримт бичгийн түвшинд харьцуулан судалж, хоёр хөтөлбөр нь үзэл баримтлалын хувьд онцлог ялгаатай байна. МУБИС-ийн сургалтын хөтөлбөр нь хөтөлбөрийн хөгжлийн чиг хандлагатай илүүтэй нийцсэн байна.

Хөтөлбөрийн бүтэц дизайн нь төрийн бодлого, сургуулийн хөтөлбөр боловсруулах, баталгаажуулах тогтолцооны хувьд ялгаатай байна. Эндээс сургууль өөрийн онцлогтой сургуулийн эрхэм зорилго, үнэт зүйл, хөгжлийн хандлага, алсын хараатайгаа холбож бие даан хөтөлбөр боловсруулах нь хөтөлбөрийн хөгжилд илүүтэй нөлөөлж байна.

Хөтөлбөрийн онол, аргазүй, чиг хандлагатай хоёр хөтөлбөрийн боловсруулалтын байдлыг ерөнхийлөн авч үзэж судлахад ӨМБИС-ийн хөтөлбөрийн тогтолцоог боловсруулалтын түвшинд байх ёстой зүйлс байгаа хэдий ч хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлох, үр дүнгийн хамаарлыг тооцох, чанарын баталгаажуулалтын хэсгийг тодорхой тусган сайжруулах шаардлага байна.

Хөтөлбөрийг үнэлэх загвар, аргазүйн хувилбар боловсруулах CIPP загварт суурилсан хөтөлбөрийн тогтолцооны үнэлгээний аргазүйн загвар боловсруулж, Хоёр хөтөлбөрт үнэлгээ хийж давуу болон сул талыг тодорхойлох, боломж болон эрсдэлийг үнэлэх, цаашид сул талаа засаж давуу тал болон боломжоо нэмэгдүүлэх, эрсдэлийг багасгах гэх мэт стратеги тодорхойлох боломжтой аргазүйн загвар болсон гэж үзэж байна.

График дизайны хоёр хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, үр дүнгийн хамаарлын тодорхойлсон байдлыг үнэлэх, харьцуулалт хийх суралцагчийн эзэмших чадварыг тодорхойлон, эрэмбэ тогтоож, хичээл бүрийн суралцахуйн үр дүнд анализ хийж аль чадваруудыг ямар хичээлүүд олгож буйг тодорхойлох аргазүйг тодорхойлов.

Агуулга, аргазүйн харьцуулсан судалгаа ийж үзэхэд ӨМБИС-д үйлдвэрлэл хэрэглээ, бизнесийн чиглэлийн 17 кредит бүхий хичээл байна. МУБИС-ийн сургалтын төлөвлөгөөний хичээлээс даруй 30 гаруй кредитээр илүү цаг судлаж байж бакалавр болж байгаа нь ӨМБИС-ийн төлөвлөгөөнөөс харагдаж байна.

Үнэлгээний тогтолцоо болон хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, чанарыг баталгаажуулах тогтолцоо, хөтөлбөрийн бичиг баримтад хэрхэн туссан тухай харьцуулан судлахад

дотоод чанарын тогтолцооны олон улсын чиг хандлагатай нийцүүлэн тодорхой тусгах шаардлага аль аль хөтөлбөрт байна. Гэхдээ хөтөлбөрийн тогтолцооны хувьд МУБИС-ийн хөтөлбөрт чанарын баталгаажуулалтын хэсэг байгаа давуу байна.

Ном зүй

- Монгол Улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, (2015), Улаанбаатар
- Монгол Улсын БШУСайдын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага МУБИС-ийн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, (2015). Улаанбаатар
- МУБИС-ийн Бакалаврын сургалтын хөтөлбөр (2016), Улаанбаатар
- БНХАУ-ын Боловсролын Яамны дээд боловсролын газрын 1998 оны 2-р тушаал, 2004 оны 21-р тушаал батлагдсан Ерөнхий дээд сургуулийн бакалаврын мэргэжлийн лавлалт ба мэргэжлийн танилцуулга. (2004), Улаанбаатар
- БНХАУ-ын БЯамны дээд боловсролын газрын 2007 оны 1 ба 2-р тушаал, (2007). Улаанбаатар
- ӨМБИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн үндсэн бүтэц, (2008), Улаанбаатар 2008 оны 9-р тушаал
- ӨМБИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр, (2009), Улаанбаатар

**Bachelor's degree curriculum has been developed and
some of the results of the study have been developed**
(Program example on Mongolia National University of Education and Inner
Mongolian Teachers University)

Jilee.J
Inner Mongolia Normal University

Abstract

There is needs to develop, evaluate, implement, and maintain a policy on all levels of education curriculum on scientific basis. In this sense, modern philosophical education streams and values should be considered in determining the purpose, structure and content of the curriculum, or evaluating how the program is based on the philosophy of flow. We studied the bachelor degree of graphic design of the Mongolian National University of Education and Inner Mongolian Teachers University at the level of the document and we identified the features, opportunities and advantages of the two programs, and identified strategies for mitigating weaknesses and risks. The purpose of the project was to develop and test. to evaluate the program's theories, methodologies and trends, develop a model and methodology for evaluating the program, compare comparative concepts of both programs and comparative research and evaluation, and evaluate and evaluate the learning outcomes of both graphic design learning outcomes and outcomes. , comparative analysis of content and methodology, evaluation system and evaluation of results, quality assurance systems, comparisons of how the program is reflected in the document, research and development of strategies to improve the vulnerabilities and risks, to develop strategies and opportunities to improve their opportunities and advantages. We examine the policies, decrees, orders, concepts of the program, program objectives, principles of the school and department's policies, and the relevance of current global approaches to the curriculum development of two universities, defined.
